

БАТЛАВ.
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

/Г.Энхмөнх/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

ТОМ НАР ЭНЕРЖИ ХХК-ийн гүйцэтгэх захирал



/Х.Тэгшээ/

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ЕСӨНБУЛАГ СУМ, ХАРЗАТ БАГИЙН
НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ “10 МВТ ХҮЧИН ЧАДАЛТАЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХУРИМТЛУУРЫН СИСТЕМ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР: 6357229

Хянасан:

Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яамны Байгаль орчны үнэлгээ, аудитын

хэлтсийн мэргэжилтэн

.....

Боловсруулсан:

Том нар энерги ХХК-ийн

зөвшөөрөл нийцлийн албаны менежер

Б. Гантөгс

2024 он



ТОМ НАР ЭНЕРЖИ ХХК

***ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН
НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ “10 МВТ ХҮЧИН
ЧАДАЛТАЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХУРИМТЛЛУУРЫН
СИСТЕМ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ***

Батлав. Гүйцэтгэх захирал



Х. Тэгшээ

Улаанбаатар хот

2024 он

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТУУД.....	2
1.1 Том нар энерги” ХХК-ний тухай	2
1.2 Төслийн зорилго.....	2
1.3 Төслийн талбайн байршил	2
1.4 Алтай-Улиастай эрчим хүчний систем.....	3
1.5 Төслийн гол ба болзошгүй нөлөөллийн тодорхойлолт.....	5
1.6 Төслийн орчны нийгмийн төлөв байдал.....	6
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОМТ).....	8
2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ	8
2.2 БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц	9
2.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	10

НЭГ. ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТУУД

1.1 Том нар энерги” ХХК-ний тухай


Төслийн нэр: “10 МВт хүчин чадалтай Эрчим хүчний хуримтлуурын систем”
Төсөл хэрэгжүүлэгч: “Том нар энерги” ХХК
Регистрийн дугаар 6357229
Улсын бүртгэлийн дугаар 9011813947
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Улаанхуаран 1
Утас: +976-9565-0580, +976-9526-1119
Имэйл: tomnarenergy@gmail.com
Төсөл хэрэгжих газрын байрлал: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг

1.2 Төслийн зорилго

Компани 4510 кодтой Гадаад худалдаа эрхлэхээс гадна 4652 кодтой “Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн худалдаа” эрхэлдэг бөгөөд энэхүү төсөл нь компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, үндэсний баялаг бүтээх, эко орчин бий болгох, ногоон бизнесийн хүрээнд “10 МВт хүчин чадал бүхий хоногт 42 мян.кВт цаг цахилгаан эрчим хүч нийлүүлэх боломжтой батарей хуримтлуурт цахилгаан станц” байгуулах зорилготой.

1.3 Төслийн талбайн байршил

Төслийн талбай нь Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төвөөс зүүн урагш аймгийн аж үйлдвэрийн зориулалтаар олгогдох газрын бүсэд байршилтай ба өөрийн аймгийн төвөөс 3.3 км, Улаанбаатар хотоос 1100 км зайд алслагдсан байна.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Говь-Алтай аймаг. Есөнбулаг сум. Харзат баг. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын 2024 оны 04 сарын 22-ны өдрийн А/51 тоот захирамжаар Харзат багийн Цэвэрлэх байгууламжийн хойд талд 8208006747 нэгж дугаартай 10,000 м² хэмжээтэй

Есөнбулаг сумын ЗДТГ-ын эзэмшилд олгосон газар дээр “Том нар” ХХК “10 МВТ-ын хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем байгуулах” төслийг хэрэгжүүлнэ.



Зураг 2. “Алтай Улиастай эрчим хүчний систем” ТӨХК-ийн “Есөнбулаг” дэд станц, 110/35/6 кВт

1.4 Алтай-Улиастай эрчим хүчний систем

Алтай-Улиастайн Эрчим Хүчний Систем (АУЭХС) ТӨХК нь 2009 оны 4 дүгээр сараас үйл ажиллагаагаа явуулж Говь-Алтай, Завхан аймгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа ба харьяандаа “Есөнбулаг Эрчим Хүч” ХХК, “Тайшир-Гуулин УЦС” ХХК, “Галуутай-Хүнгүйн УЦС” ХХК, “Тосонцэнгэлийн УЦС” ХХК зэрэг 4 компанитай. Тус систем нь Завхан аймаг дахь салбар, Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий 6 сум, давхардсан тоогоор дизель станцаар 43 сум, 2 тосгоныг эрчим хүчээр хангаж байна. Системийн нийт хэрэглээний 30%-ийг Тайширын усан цахилгаан станц хангадаг ба Говь-алтай аймгийн 5 сумыг 35 кВ-ын Ховдын Дарви шугамаар дамжуулан ББЭХС-ээс цахилгаан эрчим хүч худалдан авч хангаж, тусдаа ажиллаж байна. АУЭХС нь нийт 14 МВт-ын суурилагдсан хүчин чадал бүхий 6 усан цахилгаан станц, 2 дизель цахилгаан станц болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс бүтсэн, нийт 34,4 МВт суурилагдсан хүчин чадалтай систем юм.



Зураг 3. Техногений нөлөөллийн бүс дэх төслийн талбайн байршил, 2024 он

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн хийсэн судалгаа, судалгаанаас гарсан бодит үр дүн

№	Судалгааны төрөл, чиглэл	Судалгааны цар хүрээ	Үр дүнд үндэслэсэн бодит шийдлүүд
1	Монгол улсын эрчим хүчний системийн одоогийн байдал	<ul style="list-style-type: none"> < Монгол улсын эрчим хүчний суурилагдсан хүчин чадал < Монгол улсын цахилгаан хэрэглээний үйлдвэрлэл, тулгамдсан асуудал < Эрчим хүчний дотоодын боловсруулалтын технологийн хувилбарууд < Импортын эрчим хүчний зайлшгүй шаардлага, түүний сайн, муу талууд < Төвийн бүсийн хоногийн болон жилийн цахилгааны ачаалал, график < Дамжуулах сүлжээ болон эрчим хүчний түгээлтийн зохицуулалт < Эрчим хүчний цаашдын өсөн нэмэгдэх хэрэгцээ, нийлүүлэлтийн таац 	Бизнесийн судалгаагаа хэрэгжүүлэх шийдвэрийг гаргаж баримт бичиг бүрдүүлэхэд түншүүдтэй харилцаж эхэлсэн.
2	Эрчим хүчний хуримтлуурын систем	<ul style="list-style-type: none"> < Хуримтлуурын системийн технологи < Хуримтлуурын системийн тоног төхөөрөмж, ажиллах зарчим < Шаардлагатай засвар үйлчилгээний зайлшгүй үүсэх нөхцөл, эрсдэлүүд < Аюулгүй ажиллагааны шаардлага, стандартууд < Хөрөнгө оруулалтын олон улсын сонирхол, зээлийн нөхцөлийг судалсан. 	Технологийн олон төрөлт хувилбарыг зэрэгцүүлэн судалж сонголт хийснээр төслийн эдийн засгийн үр ашгийг тооцсон. Анхны хөрөнгө оруулалтыг тооцсон.

3	Алтай-Улиастайн эрчим хүчний системийн судалгаа	<ul style="list-style-type: none"> ◁ Бүс нутгийн байгаль цаг уур, газар зүй болон байгаль орчны нөхцөлүүд ◁ Алтай-Улиастайн эрчим хүчний байгууламжийн үйл ажиллагаа, хүчин чадал, хэрэглээний хангамж, дутагдал 	Төслийг хэрэгжүүлэх оновчтой байршлыг сонгож хуримтлуурын системийг хэрэглэх төслийг Монголд анх удаа эхлүүлж байна.
4	Монгол улсын эрчим хүчний салбарын эрх зүйн орчин	<ul style="list-style-type: none"> ◁ Эрчим хүчний талаар төрөөс баримталж буй бодлого, түүний өөрчлөлт шинэчлэл ◁ Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалт ◁ Сэргээгдэх эрчим хүчний салбарын эрх зүйн зохицуулалт 	Төслийн ГЭЗҮ боловсруулж холбогдох яамны шинжлэх ухааны мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлсэн.
5	Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой эрх зүйн орчны судалгаа	<ul style="list-style-type: none"> ◁ Байгаль орчны багц хуулиуд, эрх зүйн орчин ◁ Орон нутгийн удирдлага, засаг захиргааны нэгжийн удирлагын тухай хууль, эрх зүйн орчин 	Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой баримт бичгийн бүрдүүлбэрийг хангаж эхэлсэн.

1.5 Төслийн гол ба болзошгүй нөлөөллийн тодорхойлолт

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн тодорхойлолт Говь-Алтай аймгийн төв, Есөнбулаг сумын төв зэрэг суурьшлын давхцалын бүсэд эрчим хүчний үйлчилгээ, хангамжийг нэмэгдүүлэх батарей хуримтлуурын систем байршуулах төслийн талбайн бүс нутгийн байгаль болон амьдрах орчны төлөв байдлыг үнэлж үзээд экосистемийн хувьд эрс өөрчлөлттэй, хүн-техник-технологийн хүчин нөлөөнд ихээхэн автсан орчин болсныг дээр өгүүлсэн судалгааны дүнд үндэслэн тогтоосон байна.

Хүснэгт 2. Төслийн бүс нутгийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

Нөлөөллийн хүчин зүйлүүд	Төлөв байдлын гол үзүүлэлтүүд	Нөлөөлөл
Газар	<p>Төслийн талбайн орчинд үйлдвэр-аж ахуйн зориулалтаар газар ашиглана.</p> <p>Одоохондоо тархай сийрэгдүү ашиглалттай, дэд бүтцийн байгууламжийн төвлөрөлтэй нь давуу тал болно.</p> <p>Бүс нутаг газар дүрсийн ноцтой өөрчлөлт бүдэг, олон төрлийн үйлдвэр-технологийн үйл ажиллагаа зэрэгцдэг.</p> <p>Төсөл өөрөө эзэмшлийн талбайнхаа 90 гаруй хувийг хатуу хучилттай болгон ашиглана.</p>	Төслийн газар нь үйлдвэр-технологийн бүсэд олгогдсон сайн талтай ч газар олон төрлийн шууд нөлөөллүүд давхацсан нь өөрчлөгдсөн орчиныг үүсгэсэн. Тиймээс Хүний эрүүл мэндийг орчны бохирдлоос хамгаалах шаардлагатай.
Агаар	<p>Төслийн талбай нь нэг талаас суурьшлын бүсийн салхин доор байршиж, нөгөө талаас олон салаа хөрсөн замын дунд орсон байршилтай.</p> <p>Салхины дээдх суурьшлын бүсээс хорт хийгээр бохирдсон агаараар салхилна.</p> <p>Төсөл өөрөө агаарт бохирдол үүсгэх тоосны болоод хийн ялгарал гаргахгүй.</p>	Төслийн талбай бусад төслийн нөлөөллийн бүсэд орсон байх ба төсөл нь агаарын бохирдлын сөрөг нөлөөг бууруулах шийдэлтэй.

Усан орчин	Төслийн бүс нутагт гадаргын усны нөөц байхгүй. Төсөл хэрэгжүүлэгч технологийн хэрэгцээнд нэрмэл ус ашиглах бөгөөд түүнийг зөөвөрлөн авчирч ашиглана. Зөөврийн нэрмэл усыг худалдаж авна. Төслийн унд ахуйн хэрэгцээний усыг мөн зөөвөрлөн хэрэглэх бөгөөд зөөврийн усыг худалдаж авна.	Төслийн усны хэрэгцээг зөөвөрөөр хангах бүрэн боломжтой. Төсөл хэрэгжүүлэгч өөртөө заавал усны эх үүсвэртэй байх шаардлагагүй.
Хөрс	Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөө төслийн талбайгаар хязгаарлагдана. Төслийн эзэмшил газрын хөрсөн бүрхэвчийн 40.0 хувь нь хэдийнээ тахлагдаж эвдэрсэн. Цаашид төслийг хэрэгжүүлэхэд сүйтгэгдэх талбайн хэмжээ 90.0 хувьд хүрнэ. Төслийн талбайн ашиглалтгүй 10.0 хувьд ашиглалтын эрчим сул байна.	Хөрс-ургамал-амьдрах орчинд үүссэн өөрчлөлт болон сөрөг нөлөөллүүд ижил шалтгаантайгаас гадна бие биесээ харилцан хамааралтай байна. Тиймээс газрыг хамгаалснаар хөрсийг, хөрсийг хамгаалснаар ургамлыг хамгаалах боломжтой ба хамгааллын зарчим нь байгаль орчны суурь зарчмуудад нийцтэй байх боломжтой.
Ургамлан нөмрөг	Ургамлан нөмрөгт доройтлын индикатор ургамлын хувийн жин зонхилж байгаа ба ургамалгүй талбай хэмжээ төслийн талбайн 60.0 орчим хувьд байна. Цаашид ургамлыг биет хэмжээгээр сүйтгэх үйл ажиллагаа төслийн талбайн 90.0 хувьд хүрнэ. Төслийн талбайн ашиглалтгүй 10.0 хувьд ногоон байгууламж хийх боломжтой.	
Биологийн олон янз байдал	Төслийн талбайг чөлөөлж хатуу хучилттай болгоно. Төслийн талбайн ашиглалтгүй 10.0-д байршуулах ногоон бүсэд бүс олон зүйл ургамал байршуулна.	

1.6 Төслийн орчны нийгмийн төлөв байдал

Эрчим хүчний үйлчилгээ, хангамжийг нэмэгдүүлэх батарей хуримтлуурын систем байршуулах төслийн бүс нутагт нийгмийн өндөр ач холбогдолтой.

- МУ-ын эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлж, импортын эрчим хүчний зардлыг бууруулна;
- Нэгдсэн сүлжээний хүчдэл давтамж тогтворжиж хэрэглэгч нар чанартай эрчим хүч ашиглана;
- Хязгаарлагддаг сэргээгдэх эрчим хүчийг хуримтлуулан ашиглана;
- ОХУ-с импортолж байгаа эрчим хүчийг орлоно;
- Орон нутагт ажлын байр нэмэгдэнэ.

Хүснэгт 3. Төслийн орчны нийгмийн төлөв байдал

Нөлөөллийн хүчин зүйлүүд	Төлөв байдлын гол үзүүлэлтүүд	Нөлөөлөл
ТХГН	Төслийн талбайн ойр орон нутгийн хамгаалалтад 50 хүртэл жилээр хамгаалах заалттай 7 газар байна. Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын хамгийн ойр нь 7 км, хамгийн хол нь 41 км байршилтай.	Төслийн үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөө тодорхойлогдоогүй.

Түүх соёлын дурсгалт зүйлс	2022 оны тооллогоор Говь-Алтай аймагт Улсын хамгаалалттай 9, аймгийн хамгаалалттай 33 газрыг бүртгэсэн. Бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалуудаас Есөнбулаг суманд олдвор бүртгэгдээгүй.	Сөрөг нөлөөлөл урьдчилсан байдлаар тодорхойлогдоогүй.
Нийгмийн төлөв байдал	<p>Төсөл нь эрчим хүчний алдагдлыг бууруулахад шийдэлтэй нь нийгмийн өндөр ач холбогдолтой.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн судалгааг 7 жилийн турш нягт нямбайгаар хийж үе шаттай шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байгаа.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч нь баримт бичиг бүрдүүлбэр нь холбогдох хууль журмын дагуу бүрдсэн.</p> <p>Төслийн бүс нутгийн оршин суугчид нь эдийн засгийн төслүүдийг таньж мэдэх, төсөлд санал оруулах оролцоо бага зэргийн сулавтар.</p>	Төсөл нь орон нутгийн өргөн хэрэгцээт асуудлыг шийдвэрлэнэ гэдгээ төсөл хэрэгжүүлэгч маш сайн ойлгож мэдэрч байгаа нь нэн сайн. Оршин суугчдын оролцоог хангах, тэдний эрх ашигт нийцтэй үйл ажиллагааг төслийн хүрээнд хэрэгжүүлнэ.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОМТ)

2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт

БОМТ-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагааны хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны хяналт, хамгааллын ажлыг багцалж төлөвлөхөд оршино. БОМТ үндсэн зорилгынхоо хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

- ◁ Станцын орчинд ногоон бүс тохижуулах
- ◁ Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах
- ◁ Хог хаягдлын оновчтой менежмент хэрэгжүүлэх
- ◁ Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- ◁ Байгаль орчны хамгаалахад удирдлагын оновчтой бодлого төлөвлөж хэрэгжүүлэх
- ◁ БОМТ-нд олон нийтийн оролцоог хангах зэрэг ажил болно.

Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

БОМТ-г боловсруулахад БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, биелэлтийг тайлагнах” журмыг мөрдсөн ба төсөл нь “ХАА, үйлдвэрлэл, аялал жуулчлал, дэд бүтэц”-ийн төслийн ангилалд хамаарна.

Хүснэгт 4. БОМТ-г боловсруулахад ашигласан баримт бичгийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	Баримт бичгийн үндэслэл	Шаардлагын тодорхойлолт
1	Алтай-Улиастай эрчим хүчний системд холбогдон ажиллах “10 мвт хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем”-ийн техник эдийн засгийн үндэслэл	Төслийн хэрэгжүүлэх техник болон эдийн засгийн үндэслэлийг тодорхойлсон судалгаа, тооцооны баримт бичиг.	Төслийг хэрэгжүүлэх техник ажиллагааг нарийвчлан, технологийн болон менежментийг зардал тооцсон баримт бичиг.
2	ЭХЯамы Шинжлэх ухаан-технологийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, 2023-9-20-ны өдрийн V ээлжит хуралдаан	“10 мвт хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем” төслийг дэмжих тухай шийдвэр.	Төслийн хэрэгжих боломжийг тодорхойлсон ЭХ-ний салбарын анхан шатны зөвшөөрөл
3	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын газрын даамал Б.Дулмаагийн үйлдсэн газрын кадастр зураг	8208005520 тоот нэгж талбарын дугаартай 2381 квад.м. байршил, хэмжээ тодорхойлсон.	Төсөл хэрэгжих газрын газарзүйн байршлыг тодорхойлсон.
4	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Харзат багийн нутагт хэрэгжүүлэх “10 МВТ хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем” төслийн БОТБҮ-ний тайлан	Байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн “Эртэч наран” ХХК-д 2023 онд боловсруулсан.	БОТБҮ-ний шатанд БОННУ хийх шаардлагатай төслийн ангилалд хамаарч байгааг тогтоосон.

5	Төслийн Ерөнхий үнэлгээний дүгнэлт	БОАЖЯамны 2023-10-27-ны өдрийн 12/5673 тоот албайн бичгээр төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлсэн.	БОННУ-г 2024 оны II улиралд багтаан яаманд ирүүлэх тухай шаардлага.
6	Төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг БОУАӨЯ-ний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн	БОУАӨЯ-ний 2024 оны 09 сарын 06-ны өдрийн хуралдаанаар БОННУТайланг хэлэлцсэн.	Тайлангийн хурлаар аюултай хог хаягдлыг хэрхэн устгах талаар хууль тогтоожийн хүрээнд ажиллах зөвлөмж өгсөн
7	Төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан	БОАЖЯамны 2024-09-06-ны байгаль орны Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хурлаар танилцуулж баталгаажуулсан.	БОННУ баталгаажсан тайланг 2024 оны 10 сарын 03-ны өдөр хүлээн авсан.

2.2 БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц

Компани 2025 онд БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт 15,464.11 сая төгрөг төсөвлөж байгаа бөгөөд дараах хүснэгтэд задлан үзүүлэв.

Хүснэгт 5. 2025 онд БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний урьдчилсан зардлын хувиарлалт

№	Хийх ажлын багцууд	Урьдчилан тооцсон төсөв, төг	Хэрэгжүүлэх хуваарь				Харицусан албан тушаалтан
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
1	Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ	1,937,360.00	J	J	J	J	Б.Гантөгс Б.Бүргэд
2	Орчны тохижилт, цэцэрлэгжилтийн төлөвлөгөө	810,000.00		J	J		Б.Гантөгс Б.Бүргэд
3	Осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх	2,096,750.00			J	J	Б.Гантөгс
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	500,000.00		J			М.Сумьяадорж
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх	1,151,000.00			J	J	М.Сумьяадорж
6	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	500,000.00				J	Б.Гантөгс
7	Багийн ИНХ-д 2025 оны БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	500,000.00				J	М.Сумьяадорж Б.Гантөгс
8	Багийн ИНХ-д 2026 оны БОМТ-г танилцуулах	500,000.00				J	Б.Бүргэд М.Сумьяадорж Б.Гантөгс
Нийт		7,995,110.00					

2.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ

Станцыг үүсгэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэхэд хуримтлуурын системийн шаардлагад нийцүүлэн газар талбайг тэгшилж маш тэгш гадаргатай хайрган хучилт хийнэ.



Зураг 4. Төслийн талбайн байдал, 2024-10-10



Зураг 5. Хуримтлуурын системийг байршуулсаны дараах байдлын төсөөлөл

“Том Нар Энержи” ХХК-д боловсруулав.

Хүснэгт 6. Завсарын үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Завсарын үйл ажиллагааны сөрөг нөлөөг бууруулахад									
1	Орчны бохирдлын сөрөг нөлөө	Хайрган хучилт хийнэ.	Төслийн талбай дотор	Квад.м	92.50	12,680	1,172,960.00	2025 онд 1 удаа	БОННУ-ний сөрөг нөлөөг бууруулах зөвлөмж Хог хаягдлын тухай хууль
2	Газар, хөрс бохирдож болзошгүй	Ариутгал халдваргүйжүүлэлт хийнэ.	Төслийн талбай дахь мал, амьтны хашаатай хэсэг	Квад.м	6,550.00	18	117,900.00	2025 онд 2 удаа	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3		Бүтээн байгуулалтын үед түр ашигласан энгийн нүхэн жорлонг дарна.	Нүхэн жорлонгийн орчин.	Куб м.	21,550.00	30	646,500.00	2025 онд 1 удаа	
Сөрөг нөлөөг бууруулах нийт зардал				1,937,360.00 төгрөг					

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Монгол улсын эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн 3-рт “Хамгаалалтын зурваст ажил үйлчилгээ явуулах дүрмийн 3.6 хэсэгт хамгаалалтын зурвас дотор тарьсан мод бут нь шугам сүлжээнд хор хохирол, гэмтэл учруулах буюу үзлэг үйлчилгээ хийхэд саад болох тохиолдолд мод, бут эзэмшигч нь түүнийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох үүрэгтэй” гэж заасан.

Манай компанийн батарей хуримтлуурын станц Алтай Улиастай эрчим хүчний систем 110/35/6 кВт” ТӨХК-ийн “Алтай” дэд станцтай залгаа эрчим хүчний барилга байгууламж бөгөөд төслийн талбайн сул орон зайд хайрган хучилтын ажлыг хийхээр төлөвлөж байна.



Зураг 6. Алтай Улиастай эрчим хүчний систем 110/35/6 кВт” ТӨХК-ийн “Алтай” дэд станцтай залгаа төсөл хэрэгжүүлэх талбайн зураг 2024.10.12

Хүснэгт 7. Төслийн талбай доторхи орчны тохижилт, газрын гадаргыг хамгаалах

№	Орчны тохижилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Төслийн талбайг аюулгүй байдлын нөхцөлд тохируулан тохижуулах	Төслийн талбайн доторхи өвс, ургамлыг зулгааж хаях	Төслийн ашиглалтгүй талбай	Квад.м.	6,000	50.00	300,000.00	2025	MNS 5973:2009 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ
		Ашиглалтгүй сул талбайд хайрган хучилт хийх	ажилчдын хүчээр	төлөвлөсөн талбайн хэмжээгээр	одоо тодорхой болоогүй	Ажилчдын чөлөөт цаг ашиглалтын хүрээнд		2025 онд	
		Мод тарих	ажилчдын хүчээр	ш	300	1,700	510,000.00	2025	
2	Тохижуулж байгаа талбайг тэмдэгжүүлэх	Авчирсан хайргыг тараан тэгшлэх	Ажилчдын хүсэлтээр	Квад.м.	Жил бүр	Ажилчдын чөлөөт цаг ашиглалтын хүрээнд		2025	
Ногоон бүс тохижуулах ажлын нийт зардал				810,000.00 төгрөг					

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

Хуримтлуурын системийн бүс нутагт түүх дурсгалын биет зүйлс тэмдэглэгдээгүй бөгөөд систем нь 2381 квад.м талбай ашиглаж, үүссэн нөлөөлөл нь төслийн талбайгаас гадагшлахгүй тул түүх, дурсгалт зүйлсийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл байхгүй.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн хэрэгжилтийн хүрээнд гарч болзошгүй эрсдэлүүд: Батарей эрчим хүч хуримтлуурын системийг ашиглах шийдвэрт үнэ, ашиглах боломжтой орон зай, суурилуулалт, ашиглалт, засвар үйлчилгээний хялбар байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлнө. Энд голлох дараах эрсдэлүүд хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ⟨ цахилгаан цохих
- ⟨ гал гарах
- ⟨ шарах
- ⟨ дэлбэрэлт
- ⟨ химийн аюултай бодист өртөх.

2011-2023 оны хооронд хэд хэдэн томоохон сүлжээний эрчим хүч хуримтлуурын байгууламжид гал гарч, аюулгүй ажиллагааны түвшин сайжруулах үүднээс стандартуудыг илүү боловсронгуй болгож ирсэн туршлага олон улсад бий. Тиймээс батарей хуримтлуур ашиглаж ирсэн улс орнуудын туршлагаас шууд нэвтрүүлэх замаар осол эрсдэлээс сэргийлэх менежментийг төлөвшүүлнэ.

1. Онцгой байдал, аваар ослын үед хүн гэмтэх, осол хүрээлэн буй орчинд тархах, зэргэлдээх барилга байгууламжид тархахаас сэргийлэхийн тулд:

- ⟨ Аюултай бүсийг 2 м-ээс багагүй радиустай тусгаарлах бүсээр тусгаарлах;
- ⟨ Галын аюулгүй байдлыг хангах үүднээс тамхи татах, оч, гал гаргах зэргийг хориглох;
- ⟨ Аваар осол гарснаас хөрс, усан сан зэрэг хүрээлэн буй орчинд бохирдол тархахаас сэргийлж орц, гарцыг хаах, үйлдвэрийн бүсэд хаалттай арга хэмжээ авах

2. Онцгой байдал, аваар ослын үеийн үйл ажиллагааны дараалал:

- ⟨ *Химийн бодис задарсан тохиолдолд:* Батарей хуримтлуураас гарах хар тугалгат-хүхрийн хүчлийн батарейг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах ерөнхий шаардлага MNS 6783:2019” стандартад заасан арга хэмжээг авна;
- ⟨ *Гал түймэр гарсан тохиолдолд:* Гал гарсан тухай зарлан мэдээллийг онцгой байдлын үеийн журмаар зарлаж, галыг унтраахтай холбоотой арга хэмжээг авна. Үүнд: Ажилчдын хүчийг ашиглах, гал унтраах багт дуудлага өгөх, эмнэлгийн яаралтай тусламж дуудах, онцгой байдлын албанд дуудлага өгөх, гал унтраах хэрэгсэл /гал унтраагч, элс г.м/ гал команд иргэл байгаа нөөц бололцоогоо ашиглан /гал унтраагч, элс г.м ашиглан / галыг унтраах, хүмүүсийг галын

голомтоос гаргаж аюулгүй бүсэд хүргэх зэрэг ажиллагааг хамруулахаас гадна ажилчдыг байнгын бэлтгэл сургалтаар хангана.

Тэмдэг, тэмдэглэгээ хийх. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад гарч болзошгүй байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



Зураг 7. Хуримтлуурын системийн орчинд хэрэглэх анхааруулах тэмдгүүд

Хүний эрүүл мэндийг хамгаалах. Ажилчдад хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн тухай ойлголтыг хөдөлмөр хамгааллын сургалтаар дэлгэрэнгүй өгч ослын үед авах яаралтай тусламж, зохион байгуулалттай арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүн нэг бүрийн үүргийг тодорхой болгож заасан байна. Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах үйлчилгээ үзүүлнэ.

Хүснэгт 8. Хүний эрүүл мэндийг хамгаалах тухай зөвлөмж

Химийн бодисууд	Хүний биед нэвтрэх зам	Хамгааллын арга хэмжээ
Химийн бодисын хордлогын үед	Амьсгалын замаар хордсон үед:	Цэвар агаартай орчинд гаргах, тайван, дулаахан байлгах. Халуун цай, кофе уулгах. Шаардлагатай бол эмчид үзүүлэх
	Арьс бохирдсон бол	Бохирдсон хэсгийг ихээхэн хэмжээний усаар сайтар угаах. Шаардлагатай бол эмчид үзүүлэх.
	Нүд бохирдсон бол:	Нүдээ анилгүйгээр урсгал усаар 15 минутын турш сайтар угаах. Шаардлагатай бол эмчид үзүүлэх.
	Амаар залгисан тохиолдолд:	Их хэмжээгээр ус уух, нүүрсэн эм эсвэл сульфат натрийн /тал аяга усанд 1 хоолны халбагаар хийх/ уусмал уух. Шаардлагатай бол эмчид үзүүлэх.

Компанийн зүгээс хувийн хамгааллын хувцас хэрэгслийг тогтмол хугацаанд шалгаж, шаардлагатай бол шинэчилж, солих арга хэмжээг авч үүнтэй холбоотой зардлыг жил бүрийн үйл ажиллагааны төсөвт суулгаж өгнө.



Зураг 81. Ажилчдад олгох нэг бүрийн хамгаалах хэрэгсэлүүд

Хүснэгт 9. Осол, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний зардал

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ажлын байрны хортой нөхцөл	Хор саармагжуулах хүнсний хангамж	Станцын технологийн ажилчид	хүн/сар	24	50,000.00	1,200,000.00	байнга	<ul style="list-style-type: none"> < MNS 6783:2019 < MNS 5105:2001 < MNS 6342:2012 < MNS 6594:2016 < MNS 0042:2015 < MNS 4978:2017 < MNS 4596:2015 < MNS 4968:2015 < MNS 4992:2000
2	Галын болзошгүй эрсдэл	Нөхцөл байдлыг стандартын горимд нийцүүлэх	Засвар үйлчилгээ	бүхэл	1	266,750.00	266,750.00	жилдээ	
3	Ажлын байрны хортой нөхцөл	Хөдөлмөр хамгааллын хэрэгслийг шинэчлэх	Станцын технологийн ажилчид	хүн/жил	6	105,000.00	630,000.00	жилдээ	
Нийт			2,096,750.00 төгрөг						

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Талбай чөлөөлөх үеийн хог хаягдлын менежмент: Төслийн хог хаягдлын менежментийг 2024 онд газар талбай чөлөөлөхтэй холбоотой орчны ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажилд чиглүүлнэ. Түүнээс хойш системийн байршуулж төслийг эхлүүлснээр хог хаягдлын тогтвортой менежментэд шилжинэ.

- ◁ Засвар үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг аюултай хог хаягдал дахин боловсруулах эрх бүхий байгууллагатай гэрээ хийж зайлуулна.
- ◁ Ахуйн хог хаягдлыг өөрийн төслийн талбайд ачилтын хэмжээнд хүртэл түр хадгалж байгаад Алтай хотын тохижилт-үйлчилгээний байгууллагатай хийсэн гэрээний дагуу зайлуулна.
- ◁ Дахин ашиглах боломжтой дахивар хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилж хоёрдогч түүхий эд хүлээн авах эрх бүхий этгээдэд шилжүүлэхдээ мөн гэрээ байгуулсан байна.
- ◁ Оффисын орчинд ахуйн хог хаягдлыг ангилан ялгах нөхцөлийг бүрдүүлнэ.



Зураг 9. Ангилсан хог хаягдал ачих хүртэл түр хадгалахад зориулан бэлтгэх сав

Аюултай хог хаягдал буюу Батарейг устгалд оруулах. Төслийг хэрэгжүүлэхэд бусадтай харьцуулахад өндөр үр ашигтай, батарейны эрчим хүчийг хадгалах технологийн дунд тэргүүлэх байр суурь эзэлж байгаа Лити-ион (Li-ion) баттарейг сонгосон ба лити батарей нь илүү урт настай, аюултай засвар үйлчилгээ шаарддаггүй онцлогтой. Тухайлбал:

- ◁ LiFePO₄ батарей нь илүү аюулгүй
- ◁ LiFePO₄ батарей нь өндөр хүчин чадалтай хэрэглээнд тохиромжтой олон давуу талтай байдаг
- ◁ Лити төмрийн фосфатын батарей нь эрчим хүчний нягтрал багатай байдаг
- ◁ Environmental impact Low carbon footprint
- ◁ Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хувьд хоргүй зэрэг давуу талуудтай.

Батарей ашиглалтын хугацааг БНХАУ-ын батарей нийлүүлэгч компаниудын мэдээллээр 7-13 жил гэж тодорхойлсноос гадна хөрөнгө оруулагч нар эхний 5 жилийн баталгааг өгч байгаа, баталгааны хугацаанд гэмтэлтэй, эмчлэх шаардлагатай батарейг үйлдвэрлэгчид үнэ төлбөргүй засч сэлбэж, задалж өгөхөөр гэрээнд тусгасан. Мөн батарейг дахин сольж эмчилж засварлах чиглэлээр ашиглалтын хугацааг нэмэгдүүлж болох бөгөөд манай төслийн хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 15 жил, бид 20 орчим болно гэж тооцож байна.

Энэ нь батарейг устгалд оруулах хугацааг уртасгаж байгаа хэрэг бөгөөд БОМ-ын энэхүү төлөвлөгөөний хугацаанд батарейг устгалд оруулах шаардлага үүсэхгүй болохыг илтгэж байгаа юм. Төслийн хэрэгжилтийн 2029 оноос цааших хугацаанд батарейг устгалд оруулах асуудал үүсэж болзошгүй бөгөөд тийм нөхцөл байдлыг Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, байгууллагын Дотоод хяналтын системээр илрүүлэх болно. Хяналтын системд өгөгдсөн үзүүлэлтүүд нь станцад суурилагдсан үндсэн тоноглолын ажиллагааг хянахад зориулагдаж үйлчилгээний ажилчид богино хугацаанд засварлах боломжтой гэж төслийн ТЭЗҮ-д авч үзсэн байгаа. Уг станцын ашиглалтын үеийн хамгаалалт, хяналт, шинжилгээний систем нь доорх зүйлээс бүрдэнэ. Үүнд:

1. Видео ажиглалт
2. Батарей менежмент систем /батарейны бүхий л мэдээлэл агуулагдана/
3. Батарей хуримтлуурын станцын цэнэглэлт болон үйлдвэрлэл үр ашиг
4. Үр ашгийн оновчлол
5. Алсын удирдлага
6. Гэмтлийн дүгнэлт гаргах ажилбаруудыг ТЭЗҮД-д тодорхойлсон болно.

Тиймээс ашиглалтын үеийн техник, тоног төхөөрөмж, түүний дотор баттарей засварлах ажлаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хянахад ОХШХ-г мөрдөж ажиллана.

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Хүрээлэн буй орчны бохирдол	Ариутгал халдваргүйжүүлэлт хийнэ.		Сөрөг нөлөөг бууруулах төлөвлөлтөнд тооцсон.					<ul style="list-style-type: none"> ◁ Хог хаягдлын тухай хуулийн 20.1, 20.2, 21.1 зээлтууд ◁ MMS5924:2015 ◁ Алтай ИТХ-ын тэргүүлэгчдийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох тухай тогтоол ◁ Есөнбулаг сумын ЗД-тай байгуулах Хог хаягдлын гэрээ
		Хуримтлагдсан бохир нүхийг цэвэрлэнэ.		Сөрөг нөлөөг бууруулах төлөвлөлтөнд тооцсон.					
2	Ахуй хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдал	Станцын ажилчид	Холбогдох талтай хийсэн гэрээний үнийн дүнг үйл ажилгааны зардалд тусгаснаар			Байнга	2025 онд 1 удаа	
		Ангилсан хаягдал түр хадгалах сав бэлтгэх	Эрх бүхий этгээдтэй хийсэн гэрээ	ширхэг	125,000.0	4	500,000.00		
		Ахуйн шингэн бохирыг хадгалж соруулдаг цооног хийх	Барилгын гүйцэтгэгч	Төслийн хөрөнгө оруулалтын зардлаар гүйцэтгэнэ.			2025 онд 1 удаа		
Нийт		500,000.00 төгрөг							

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Сөрөг нөлөөллийн хяналтын цэгүүдийг байршуулах

Сөрөг нөлөөллийн тархалт, эрчмийг хянаж байх зорилготой орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах асуудлуудыг хамруулна. Үүнд:

- ◁ Экологийн хяналт, удирдлагын арга хэмжээ
- ◁ Засвар үйлчилгээний үед ялгарах, алдагдах хүүхрийн хүчлээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад тавих шаардлага
- ◁ Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад тавигдах шаардлагыг хангахад орчны хяналт шинжилгээг чиглүүлнэ.



Зураг 10 Байгаль орчны хяналт мониторинг хийх цэгүүдийн байршил

Хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Хяналт мониторингийн судалгаа, ажиглалт, дээжлэлтийн хугацааг 11 дүгээр хүснэгтээр үзүүлсэн ба төслийн байгаль орчны хяналт мониторингод 1,151,000.00 сая төгрөг төсөвлөв.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
<i>Ажлын байрны орчин</i>								
1	Төслийн талбайн орчны агаар дахь хүхрийн давхар исэл	Төслийн талбай болон түүний орчны 500 с-ийн радиуст	Улиралд 1 удаа	2 байршилд	312,500.00	625,000.00	Мэргэлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.	• MNS 6783:2019 • MNS 5105:2001
2	Төслийн талбайн агаар дахь тоос, тоосонцор		Улиралд 1 удаа	2 байршилд				
<i>Усны хяналт шинжилгээ</i>								
4	Унд, ахуйн усны чанар,	Оффис дахь ус нөөцлөх савнаас	Улиралд 1	Зөөврийн ус	60,000.00	240,000.00	магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжилгүүлнэ.	• MNS 6783:2019 • MNS 5105:2001
5	Зөөврийн ус хадгалах савны цэвэрлэгээ ариутгал хийх	Оффис дахь ус нөөцлөх сав	Сард 1 удаа	Жилд 12	-	-	Нэг ажилтанд нэмэлтээр ажил үүргийн хуваарьт нь оруулж гүйцэтгүүлнэ	• MNS 6783:2019 • MNS 5105:2001
<i>Хүрээлэн буй орчны хяналт шинжилгээ</i>								
6	Хөрсний нянгийн бохирдол	Бохирын цооногийн орчин	Жилд 2	1 байршилд	77,000.00	154,000.00	Магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжилгүүлнэ	• MNS 6783:2019 • MNS 5105:2001
7	Хөрсний хүнд металлын бохирдол		Жилд 2	1 байршилд	66,000.00	132,000.00		
Нийт		1,151,000.00 төгрөг						

БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Компани байгаль орчны хамгаалал, осол эрсдлээс хамгаалах чиглэлд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- ◁ ХАБ-ын сургалтын хөтөлбөрийг боловсруулж мөрдөнө. Хөтөлбөрт хөдөлмөр хамгааллын чадавхыг дээшлүүлэх замаар осол эрсдэлийг бууруулж, эрсдэлийг аль болох эрт, осолд дөхсөн тохиолдолд илрүүлэх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж нөхцөлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалт оруулна.
- ◁ Орон нутагтай болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах олон талт гэрээг хийх, гэрээний үүргийн биелэлтүүдийг хянах
- ◁ Сумын ЗДТГ-тай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд сумын хөгжлийн бодлогод нэмэр болохуйц бодит ажилд оролцоно.
- ◁ БОННУ-ний зөвлөмжийг хэрэгжүүлэх, БОМТ-ний хэрэгжилтийг хангуулахад БОХАБ-ын асуудал хариуцсан ажилтныг томилно. Томилогдсон ажилтан нь компанийн орон нутаг дахь олон нийтийн харилцааг мөн давхар хариуцахаар зохион байгуулна.
- ◁ БОМТ-ний биелэлтэд хяналт тавих ажлыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянан батлах журмын дагуу зохион байгуулна.

Хүснэгт 22. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлтийн зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төг	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан
			2025 онд				
			I улирал	II улирал	III улирал	IV улирал	
A	1	2	3	4	5	6	7
1	ХАБ-ын сургалтын хөтөлбөрийг боловсруулах	Үйл ажиллагааны зардал болон цалингийн санд багтаана.				БОХАБ-ын мэргэжилтэн	
2	Олон талт гэрээ хэлцэл хийх	500,000.00				500,000.00	Гүйцэтгэх захирал
Нийт		500,000.00	-	-	-	500,000.00	-

БОМТ-ний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ-ний хэрэгжилт, ирэх оны БОМТ болон нийгмийн хариуцлагын гэрээний биелэлтийг орон нутаг танилцуулах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулна. Үүнд:

- ◁ Үйлдвэрийн БОМТ-г хууль, журамд заасны Харзат багийн ИНХ-д хэлэлцүүлж холбогдох баримт бичгийг БОМТ-ний биелэлтийн тайланд хавсаргана.
- ◁ Бүс нутгийн иргэд, оршин суугчдад төслийн үйл ажиллагааг танилцуулах сурталчилгааны ажлыг жилд 1 удаа зохион байгуулна.

- ◁ Есөнбулаг сумын ЗД буюу Алтай хотын захирагчтай гэрээ байгуулсан Нийгмийн хариуцлагын үүргээ биелүүлж, тайлагнаж дүгнүүлнэ.

Хүснэгт 33. 2025 оны БОМТ-ний хэрэгжилтийг орон нутгийн олон нийтэд тайлагнах, 2026 оны БОМТ-г танилцуулах ажлын зардал

№	БОМТ, БОМТ-ний оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
А	1	2	3	4	5	6	7
1	Багийн ИНХ	ИНХуралд илтгэл тавих	2025 оны БОМТ-г тайлагнах	2025 оны 10 сард	500,000.00	БОХАБ хариуцсан мэргэжилтэн	Багийн төв
2	Багийн ИНХ	ИНХуралд илтгэл тавих	2026 оны БОМТ-г танилцуулах	2025 оны 10 сард	500,000.00	БОХАБ хариуцсан мэргэжилтэн	Багийн төв
Нийт		1,000,000.00					



Огноо/Date: 2024/12/02 16:07:54

Шилжүүлгийн мэдэгдэл/Transaction report

Журналын №/Journal №: 91029000102046

Системийн огноо/System Date: 2024/12/02 16:07:54

Харилцагчийн дугаар/Customer №: 13202566

Нэр/Name: ТОМ НАР ЭНЕРЖИ

Дт	Дансны дугаар/Account №	Нэр/Name:	Дүн/Amount:	Ханш/Rate:
	ТОМ НАР ЭНЕРЖИ	MN310030003023811111	3,997,555.00 MNT	1.0
/ 3,997,555.00 /				
Кт	Банкны дугаар/Bank №:	Банкны нэр/Bank Name:	Дүн/Amount:	Ханш/Rate:
	90	ТӨРИЙН САН	3,997,555.00MNT	1.0
	Дансны дугаар/Account №:	Нэр/Name:		
	100050155402	Га.Есөнбулаг БХНСэргээлт барьц		

Гүйлгээний утга/Transaction description:
6357229 БОМТ-2025 БАТАЛГААНЫ ТӨЛБӨР 50%

Харилцагч танд баярлалаа/Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified

Салбар, тооцооны төв/ Branch, sub-branch:

Банкны ажилтны гарын үсэг/Signature:

Банкны ажилтны тамга/Stamp:

_____Он/Year(YYYY)_____Сар/Month(MM)_____Өдөр/Day(DD)

Тайлбар: Та Капитрон банкны дурын салбарт баримтаа авч очин баталгаажуулах боломжтой.